



Өлзий
Энвйронментал
ХХК

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

www.ulziienvironmental.mn



КОМПАНИЙН ТУХАЙ

“ӨЛЗИЙ ЭНВАЙРОНМЕНТАЛ” ХХК нь 2020 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд уул уурхай, дэд бүтэц болон хөгжлийн төслүүдийн төлөвлөлт, барилга байгууламж, ашиглалт, хаалтын бүх үе шатанд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх цогц зөвлөх үйлчилгээг үзүүлж ирсэн.

Бидний үйл ажиллагаа нь байгаль орчны хууль, журам, стандартыг чанд мөрдөхөөс гадна олон улсын сайн туршлагад нийцсэн, шинжлэх ухаанд суурилсан, тогтвортой шийдлүүдийг санал болгоход чиглэгддэг. Манай хамт олон нь байгаль орчны салбарт олон жилийн туршлага, мэдлэгтэй салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөх инженерүүд, мэргэжилтнүүдээс бүрддэг.

Бид нөхөн сэргээлт, экологийн тэнцвэрийг сэргээхэд чиглэсэн орчин үеийн техник, технологи, шинэлэг аргачлалуудыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, харилцагч байгууллагуудын байгаль орчны эрсдэл, сорилтыг хамтран шийдвэрлэхэд байгальд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжих бодит үр дүнтэй шийдлүүдийг санал болгож хамтран ажиллаж байна.

БИДНИЙ ТУРШЛАГА

Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажил
(Биологийн болон техникийн нөхөн сэргээлт)

175

Га

Мод үржүүлэх, ойжуулах
технологийн инновацын
туршилт, хөгжүүлэлт

35

Төсөл

Байгаль орчны үнэлгээ
менежментийн зөвлөх
үйлчилгээ

2

Төсөл

Байгаль орчны хяналт
шинжилгээ

5

Төсөл

Биологийн төрөл зүйлийн
судалгаа, менежментийн
төлөвлөгөө

2

Төсөл

Ойжуулах, ойг нөхөн сэргээх
судалгаа, зураг төсөл

5

Төсөл

Мод үржүүлгийн газар
байгуулж ашиглалтад
оруулах төслийн ТЭЗҮ

8

Төсөл

Уурхайн нөхөн сэргээлт,
хаалтын менежментийн
төлөвлөгөө

5

Төсөл

МАНАЙ САНАЛ БОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭ



Эвдэрсэн газрын нөхөн
сэргээлт хийх



Байгаль орчныг хамгаалах,
нөхөн сэргээх туршилт,
судалгаа



Байгаль орчны
нөлөөллийн үнэлгээ



Байгаль орчны
мониторинг (ОХШХ)



Байгаль орчны
менежментийн зөвлөх
үйлчилгээ



Уурхайн нөхөн сэргээлт,
хаалтын менежментийн
төлөвлөгөө



Ойжуулалт, МҮГ-н
төлөвлөлт, судалгаа,
туршилт



Ойн менежментийн зөвлөх
үйлчилгээ



Орон нутгийн харилцаа,
компанийн нийгмийн
хариуцлагын зөвлөх
үйлчилгээ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид захиалагч, хамтрагч байгууллагынхаа үйл ажиллагаа, онцлогт тохирсон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулахад бодит байдалд хэрэгжихүйц шийдэл гарган тогтвортой хамтран ажиллана.

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ


- Манай байгууллагын ажилтнууд, мэргэшсэн мэргэжилтнүүд, зөвлөхүүд
- Бидний харилцагч, хамтрагч байгууллагууд
- Харилцагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн цогц үйлчилгээ



МАНАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ

Бид захиалагч байгууллагын хэрэгжүүлж байгаа төслийн үйл ажиллагаанд ТЭЗҮ боловсруулах үе шатнаас эхлэн төслийн бүтээн байгуулалтын үе шат, төслийн урт хугацааны үйл ажиллагаа болон хаалт хүртэлх хугацаанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр цогц үйлчилгээ үзүүлж урт хугацаанд тогтвортой хамтран ажиллаж байна.

- Төслийн БОНУ, БОМТ, биологийн олон янз байдлын судалгаа, мониторинг хийх
- Уурхайн хаалт, нөхөн сэргээлт, ойжуулалтын төлөвлөлт, зураг төсөл боловсруулах ба гүйцэтгэлийн мониторинг хийх
- Нөхөн сэргээлт, ойжуулалт, байгалийн болон модлог ургамал үржүүлэхэд зориулсан судалгаа хөгжүүлэлт, туршилт (R&D) хийх
- Эвдэрсэн газрын биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх, арчлан ургуулах
- Ойжуулалт, ойн менежментийн зөвлөх үйлчилгээ
- Төслийн БОНЗ, нийгмийн хариуцлагын зөвлөх үйлчилгээ



МАНАЙ МЭРГЭЖЛИЙН БАГ ХАМТ ОЛОН



Д.ӨЛЗИЙБАЯР

Бакалавр (Ой судлал), Бизнесийн
удирдлагын магистр (МВА), Үүсгэн
байгуулагч | Захирал

Д.Өлзийбаяр нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн нөөцийн тогтвортой менежментийн чиглэлээр 23 жилийн туршлагатай мэргэжилтэн юм. Тэрээр уул уурхайн компаниуд, төрийн байгууллагууд болон олон улсын хөгжлийн түншүүдтэй хамтран ажиллаж, байгаль орчны бодлогын шинэчлэл, сайжруулалтын төсөлд судлаач, зөвлөхөөр ажиллаж ирсэн.

2020 оноос тэрээр өөрийн хуримтлуулсан мэдлэг, дадлага туршлагадаа тулгуурлан Өлзий Энвйронментал ХХК-г үүсгэн байгуулж, уул уурхай, дэд бүтэц, хөгжлийн төслүүдэд дараах чиглэлээр мэргэжлийн зөвлөх болон гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна:

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, арчилгаа, туршилт судалгаа хийх
- Уурхайн хаалт, нөлөөллийн үнэлгээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- Хууль эрх зүйн нийцэл, байгаль орчны гүйцэтгэлийг үнэлэх, бодлогын зөвлөмж боловсруулах
- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх

Түүний удирдлага дор тус компани нь шинжлэх ухаанд суурилсан хандлага, тогтвортой хөгжлийг дэмжих зорилго, Монгол Улсын байгаль орчны бодлого, зохицуулалттай нийцсэн шийдэл санал болгож хамтран ажилладаг нэр хүндтэй байгууллага болон өргөжсөн.

ӨЛЗИЙ
ЭНВАЙРОНМЕНТАЛ ХХК



Х.БИЛГҮҮН

Бакалавр (Ойн судлал), Магистр
(Биологи)

Х.Билгүүн нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр 23 жилийн туршлагатай мэргэжилтэн бөгөөд уул уурхайн компаниуд болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран ажилласан арвин туршлагатай. Тэрээр мод үржүүлэг, ойжуулалт, ойн судалгаа зэрэг чиглэлээр олон төслийн судлаач, зөвлөхөөр оролцож ирсэн.

2021 оноос хойш Өлзий Энвйронментал ХХК-ийн багийн гишүүнээр ажиллаж:

- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
- Мод үржүүлэг, ойжуулалтын судалгаа, туршилт
- Төсөл, төлөвлөгөө боловсруулах
- Говь цөлийн бүсэд мод, байгалийн ургамал үржүүлэх
- Биологийн нөхөн сэргээлт хийх зэрэг ажлуудад идэвхтэй оролцож байна.

Түүний судалгаанд суурилсан мэдлэг, практик туршлага нь говийн бүсэд тохирсон, тогтвортой нөхөн сэргээлтийн шийдлүүдийг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.



Ш.ДЭЛГЭРСАЙХАН

/PhD/, Бакалавр (Хөрс судлаач)
| Магистр (Химийн инженер
технологи), Доктор (Хүрээлэн буй
орчны химийн инженер)

Ш.Дэлгэрсайхан нь хөрс, ус, агаарын чанарын хяналт шинжилгээ, бохирдсон хөрс, усны саармагжилт ба цэвэршүүлэх судалгаа шинжилгээний технологи боловсруулах, нөхөн сэргээлтийн судлаач, зөвлөх зэрэг чиглэлээр 20 жилийн ажлын туршлагатай. Тэрээр Монгол, Орос, Хятад, Герман, Америк, Австрали, Япон, Солонгос зэрэг орны мэргэжилтнүүдтэй хамтран 30 гаруй үндэсний болон олон улсын төсөл дээр амжилттай ажилласан.

Тэрээр дараах чиглэлээр мэргэшсэн:

- Хөрсний генетик шинж чанар, ангилал зүй
- Хөрсний үржил шимт чанарыг нэмэгдүүлэх бордоо, усалгааны норм тогтоох
- Хүрээлэн буй орчны ландшафтын геохимийн инженерчлэл
- Техник болон биологийн нөхөн сэргээлт
- Хөрс, усны орчны хяналт шинжилгээ

2021 оноос хойш Өлзий Энвйронментал ХХК-д зөвлөхөөр ажиллаад, 2024 оноос нөхөн сэргээлтийн менежерээр ажиллаж байна:

- Техник болон биологийн нөхөн сэргээлт
- Нөхөн сэргээлтийн дараах мониторинг
- Бэлчээрийн мониторинг
- Шимт болон шимэрхэг хөрсний мониторинг
- Хөрс, усны шинж чанарын орчны хяналт шинжилгээ
- МУГ-ын бордоо, усалгааны норм тогтоох зэрэг ажлуудад оролцож байна.

Эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт, судалгаа-туршилтын төслүүдийг удирдаж, шинжлэх ухаанд суурилсан нөхөн сэргээлтийн шийдлүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.



Р.МӨНХБАЯР

Бакалавр Ойн инженер, Уурхайн
нөхөн сэргээлтийн технологи

Р.Мөнхбаяр нь ойн менежмент, байгаль орчны хамгаалал, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн чиглэлээр 23 жилийн туршлагатай ахлах мэргэжилтэн юм. Тэрээр ил уурхайн хаягдал чулуулгийн овоолго нөхөн сэргээх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, ногоон байгууламж хөгжүүлэх чиглэлээр мэргэшсэн.

2024 оноос хойш тэрээр Өлзий Энвйронментал ХХК-д нөхөн сэргээлт, ойжуулалтын ахлах мэргэжилтнээр ажиллаж, "Оюу Толгой" ХХК-ийн үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудын технологийг боловсруулах, хэрэгжүүлж байна.

Түүнчлэн тэрээр Монгол Улсын "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд:

- Мод үржүүлгийн талбайн байршил сонгох
- Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах
- Ойжуулалтын аргачлал, технологийн заавар боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг хариуцан ажиллаж байна.

Ойн инженерчлэл болон уурхайн нөхөн сэргээлтийн технологийн чиглэлээрх хосолсон мэдлэг, ур чадвар нь Монгол орны хуурай, гандуу бүс нутгийн тогтвортой нөхөн сэргээлт хийхэд чухал хувь нэмэр болж байна.



Ц.МЯДАГМАА


MSc Байгаль орчны инженер

Ц.Мядагмаа нь байгаль орчны техникийн менежмент болон эрсдэлийн удирдлагын чиглэлээр 12 жилийн туршлагатай мэргэжилтэн юм. Тэрээр олон улсын Jacobs/Worley байгууллагатай хамтран Оюу Толгойн гүний уурхайн өргөтгөлийн төсөлд ажиллаж, байгаль орчны хууль, стандартад нийцүүлэх, тогтвортой хөгжлийн санаачилгуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан ажилласан.

2023 оноос хойш тэрээр Өлзий Энвйронментал ХХК-д төслийн менежер, багийн ахлагчаар ажиллаж, уул уурхайн төслүүдийн хүрээнд дараах чиглэлээр ажиллаж байна:

- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
- Байгаль орчны менежментийн зөвлөх үйлчилгээ
- Уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах
- Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг дэмжих стратегийн боловсруулалт

Ц.Мядагмаагийн мэргэжлийн ур чадвар, олон улсын төсөл дээр ажилласан туршлага нь уул уурхайн салбарын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайн хаалт, нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсаар байна.



Б.ОЧИРХУЯГ

Бакалавр Ойн инженер

Очирхуяг нь ойн инженерийн чиглэлээр 11 жилийн ажлын туршлагатай мэргэжилтэн бөгөөд мод үржүүлэг, ногоон байгууламжийн төлөвлөлт, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, ойжуулалт болон байгаль орчны хяналт шинжилгээний ажлаар мэргэшсэн. Тэрээр уул уурхайн салбарт нөхөн сэргээлт, ойжуулалтын олон төсөлд амжилттай ажиллаж, урт хугацааны экологийн үр дүнд чиглэсэн шийдлүүдийг хэрэгжүүлж ирсэн.

2021 оноос хойш Өлзий Энвйронментал ХХК-ийн багийн гишүүнээр ажиллаж, уул уурхай болон дэд бүтцийн төслүүдийн хүрээнд эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, мод үржүүлэг, суулгацын аж ахуйн менежмент, ойжуулалтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилт, нөхөн сэргээлтийн үр дүнг үнэлэх байгаль орчны хяналт, шинжилгээ зэрэг чиглэлээр ажиллаж байна.



Б.БУЯНЖАРГАЛ

Бакалавр Хөдөө аж ахуйн машин механизм

Б.Буянжаргал нь эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, мод үржүүлгийн техник, тоног төхөөрөмжийн ашиглалт болон механикжуулах чиглэлээр 8 жилийн туршлагатай инженер-механикийн мэргэжилтэн юм. Тэрээр нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнтэй, бүтээмжтэй зохион байгуулахын тулд техник, тоног төхөөрөмжийн зөв сонголт, ашиглалт, засвар үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн.

2024 оноос эхлэн Өлзий Энвйронментал ХХК-ийн багт нэгдэж, нөхөн сэргээлтийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, техникийн найдвартай ажиллагааг хангах зохион байгуулалт, механикжуулсан нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт зэрэг чиглэлээр ажиллаж байна.



Э.БАТТУЛГА

Бакалавр Байгаль орчны хяналт, үнэлгээ

Э.Баттулга нь уул уурхайн салбарт 13 жилийн туршлагатай байгаль орчны хяналт, үнэлгээ, сөрөг нөлөөллийг бууруулах, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх чиглэлээр ажилласан туршлагатай ахлах мэргэжилтэн юм. Тэрээр олон уурхайн компанитай хамтран байгаль орчны хууль, стандартын хэрэгжилтийг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах шийдлүүдийг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж ирсэн.

2024 оноос хойш Өлзий Энвйронментал ХХК-д ажиллах хугацаандаа тэрээр:

- Уурхайн эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Байгаль орчны хяналт, шинжилгээ, тайлагнал.
- Байгаль орчны менежментийн зөвлөх үйлчилгээ зэрэг ажлуудад идэвхтэй оролцож байна.

ӨЛЗИЙ ЭНВАЙРОНМЕНТАЛ ХХК




Б.ТҮВШИНЖАРГАЛ

Бакалавр Нөхөн сэргээлт

Бү.Түвшинжаргал нь говийн бүс нутагт эвдэрсэн газрын биологийн нөхөн сэргээлт, мод үржүүлэг, ногоон байгууламж байгуулах, гадна тохижилтын чиглэлээр 6 жилийн туршлагатай мэргэжилтэн юм. Тэрээр эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, ойжуулалт, доройтсон ойн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөлт зэрэг олон төрлийн төслүүдэд амжилттай ажилласан.

2024 оноос хойш Өлзий Энвйронментал ХХК-ийн багт нэгдэж: Эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт, арчилгаа, усалгааны ажлын гүйцэтгэл, Үрийн бэлтгэл болон тарих ажлыг удирдан зохион байгуулж ажиллаж байна. Түүний говийн бүсийн нөхцөлд дасан зохицсон нөхөн сэргээлтийн мэдлэг, ур чадвар нь манай компанийн төслүүдийн амжилтад чухал хувь нэмэр оруулж байна.



Ба.ТҮВШИНЖАРГАЛ

Бакалавр Үйлдвэрлэлийн экологи
Магистр Физик экологи

Ба.Түвшинжаргал нь байгаль орчны менежмент, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, орчны хяналт шинжилгээ, сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөх үйлчилгээний чиглэлээр 48 төсөл хөтөлбөр дээр 6 жил ажилласан туршлагатай.

2024 оноос "Өлзий Энвйронментал" ХХК-ийн багт нэгдэж газар зүйн мэдээллийн систем ашиглалт, нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглан ойжуулах талбайн байр зүйн зураглал хийх, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн байр зүйн зураглал хийх, нөхөн сэргээлт, байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тайлан мэдээ боловсруулалтын ажил гүйцэтгэж байна.



БАЙГАЛЬ ОРЧНЫ СУДАЛГАА, ХЭМЖИЛТ, МОНИТОРИНГИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ

1. TSI Dust Trak 8533 DRX Aerosol Monitor (PM1.0, 2.5, 10.0, TPM) - Агаарын тоосжилт хэмжигч багаж
2. Aeroqual Ranger - Portable Air Quality Monitor - Агаарын чанар, тоосжилт хэмжилтийн багаж
3. IN-SITU dipper Water level meter 100m, 30m, Water sampling BAILER - Гүний усны түвшин хэмжигч-100, 30 метр, ус дээжлэгч
4. PALINTEST 8000 photometer, усны чанарын шинжилгээний зөөврийн багаж
5. Хөрсний дээжлэгч, хөрсний нягт pH хэмжигч, хөрсний хэв шинж тодорхойлогч багаж
6. EVO II Drone
7. DJI Mavic 3 Multispectral-RTK
8. Garmin Oregon 750 GPS –GPS



Бид уул уурхайн төслүүдийн талбайд улирал тутмын болон жил тутмын байгаль орчны мониторингийн ажил гүйцэтгэх үйлчилгээ үзүүлж байна.

- 1 Уул уурхайн төслийн байгаль орчны хяналт шинжилгээ (ОХШХ)
- 2 Биологийн олон янз байдлын мониторинг
- 3 Нөхөн сэргээлт, ойжуулалтын мониторинг
- 4 Туршилт, судалгааны ажлын хяналт мониторинг
- 5 Шимт, шимэрхэг хөрсний чанарын мониторинг

ДРОНООР ГҮЙЦЭТГЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ СУДАЛГАА, МОНИТОРИНГ

Дроны зураглал нь байгаль орчны судалгаа, мониторингийн өндөр үр дүнтэй аргачлал бөгөөд нарийвчлалтай орон зайн мэдээллийг боловсруулан байгаль орчны менежмент, нөхөн сэргээлт, хамгаалалтын шийдвэр гаргалтыг дэмждэг чухал хэрэгсэл юм.

Манай дронд суурилсан байгаль орчны судалгаа, мониторингийн үйлчилгээ дараах чиглэлүүдийг хамарна:

- ArcGIS, QGIS, Pix4D зэрэг мэргэжлийн программ ашиглан орон зайн болон байр зүйн баталгаатай өгөгдлийг боловсруулж, зураглал хийх
- Ойжуулалт, нөхөн сэргээлтийн төслийн талбайг нарийвчлан төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт, өсөлт ургалтын мониторинг хийх
- Ургамлын бүрхэвчийн төлөв байдлыг тодорхой давтамжтайгаар үнэлэх, өөрчлөлтийг хянах
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг үнэлэх, бууруулах чиглэлийн бусад төлөвлөлт, мониторингийн ажлуудыг гүйцэтгэх

Энэхүү дэвшилтэт технологи нь байгаль орчны төлөв байдлыг бодитойгоор үнэлж, экосистемийн тэнцвэрт байдалд суурилсан шийдвэр гаргах үндэс болдог.





ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Бид Монгол улсын болон олон улсын стандартын дагуу эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг гүйцэтгэхдээ хүн, мал, амьтанд аюулгүй болгон хэлбэршүүлж, байгалийн унаган төрхөд ойртуулан шинжлэх ухааны үндэслэлтэй дэвшилтэт арга зүй, шинэлэг технологиудыг ашиглаж байна.

Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн цогц үйлчилгээг үзүүлэхдээ дараах үндсэн аргачлалуудаар хийж гүйцэтгэж байна. Үүнд:

Эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт

- Аюулгүй болгох, хэлбэржүүлэх
- Налуугийн тогтворжилтыг хангах
- Хөрсний үржил шим нэмэгдүүлэх

Биологийн нөхөн сэргээлт (Аргачлал)

1. Нутгийн ургамлын суулгац тарьж ургуулах
 - Далд үндэстэй суулгац, Ил үндэстэй суулгац
2. Нутгийн ургамлын үр тарьж ургуулах
 - Усан үрлэгээ (Hydroseeding)
 - Хуурай үрлэгээ (Drill seedling)
 - Үрийн бөмбөлөг (Seed ball)

Манай байгууллагын нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх арга, технологиуд нь дээрх аргачлалуудаар хязгаарлагдахгүй бөгөөд би цаашид уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон шинэ, шинэлэг арга технологиудыг ашиглан гүйцэтгэх туршилт судалгааны ажлуудыг амжилттай гүйцэтгэж байна.





НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ



Ловол.904 Трактор нүх
ухагч төхөөрөмжтэй



Усны машин 25 тонн
(Noth benz)



Усан үрлэгч машин
(Finn hydroseeder)



Тарьц суулгацын тээвэр
(Hyundai.5TON)



Тээврийн хэрэгслүүд
(Hyundai.Starex-TQ, Volkswagen.
Amorok-2H)



Ловол.TD904 Трактор
үрлэгч төхөөрөмжтэй



Toyota Land Cruiser 200



Усны машин 25 тонн
(Noth benz)



БИДНИЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ



Тэлмэн Ресурс ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэл: Уул уурхайн байгаль орчны менежмент



Сора Интернэшнл ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 5

- Гол Чиглэлүүд: Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт хангах, уурхайн нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээ.



Жавхлант Орд ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэл: Уурхайн нөхөн сэргээлт ба хаалтын төлөвлөгөө.



Баян Айраг Эксплорэйшн ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэл: Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө.



Спейшл Майнинг Сервисес ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэл: Тэсрэх бодисын үйлдвэрийн байгаль орчны хяналт шинжилгээ.



Степ Голд ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 14

- Гол Чиглэлүүд: Байгаль орчны хяналт шинжилгээ, биологийн олон янз байдлын судалгаа, уурхайн хаалтын төлөвлөгөө
- Ойжуулалтын төлөвлөгөө



Оюу Толгой ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 19

- Гол Чиглэлүүд: Хөрс ба ургамлын мониторинг, судалгаа
- Нөхөн сэргээсэн талбайн судалгаа, үнэлгээ
- ОТ 100 САЯ МОД ХӨТӨЛБӨРИЙН зөвлөх үйлчилгээ
- Хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөө
- Мод үржүүлгийн газар байгуулах ТЭЗҮ
- Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн төлөвлөлт, зураг төсөл
- Нөхөн сэргээсэн талбайн хяналт мониторингийн үйлчилгээ
- Биологийн олон янз байдлын хяналт мониторинг хийх
- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт

- Биологийн нөхөн сэргээлт - 175 га
- Техникийн нөхөн сэргээлт - 54га



Мандал Ресурс ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэлүүд: Байгаль орчны хяналт мониторинг.



Эрдэнэ Монгол ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 2

- Гол Чиглэлүүд: Уурхайн хаалтын төлөвлөгөө ба агаарын чанарын мониторингийн зөөврийн багаж нийлүүлэлт



Мознко ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэл: Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.



АМЕР2 Төсөл

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэл: Уурхайн хаалтын санхүүгийн тооцооны сургалт



Грөүт Финанс Аудит ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэл: Байгаль орчны удирдлага, уурхайн нөхөн сэргээлт, хаалтын сургалт.



МЕРИТ Төсөл

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 2

- Гол Чиглэлүүд: Байгаль орчны мониторингийн зөөврийн багаж нийлүүлэлт



"Бороо гоулд" ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэлүүд: Агаарын чанарын хяналтын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт.



Кью Эм Си ХХК

Нийт Үзүүлсэн Үйлчилгээний Тоо: 1

- Гол Чиглэл: Үйлдвэрийн төслүүдийн ТЭЗҮ-ний байгаль орчны менежментийн төлөвлөлт

Усны мониторингийн зөөврийн багаж нийлүүлэлт

- Эх Монголын Байгаль ХХК
- Гринтрэндс ХХК
- "Зэс Эрдэнийн Хувь" ХХК
- Баялаг Эко ХХК



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮД

01.

Газрын хэвлийн
нөхөн сэргээлт



02.

Ойн тооллого,
ой зохион байгуулалт



03.

Байгаль орчны
нөлөөллийн үнэлгээ



САЛБАРЫН ГИШҮҮНЧЛЭЛ

01.

Байгаль орчны үнэлгээ
эрхлэгчдийн холбоо

02.

Ойн тооллого, ой зохион байгуулалт
эрхлэгчдийн холбоо





Өлзий
Энвйронментал
ХХК

ХОЛБОО БАРИХ

Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чагдаржавын гудамж 32/2
SAV PLAZA оффис, 4 давхар 402 тоот

+967 7608 0088,
+967 7711 8659,
+967 9905 8659

www.ulziienvironmental.mn
info@ulziienvironmental.mn

